



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2024 оны 09 сарын 13 өдөр

Дугаар 415

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацаа сунгах,
үнийг шинэчлэн тогтоох зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8 дахь хэсэг, 31 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн 2 дахь заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 7.1, 7.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. "Диспетчерийн үндэсний төв" төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 5 нэрийн, нийт 9,925,329,253.11 (есөн тэрбум есөн зуун хорин таван сая гурван зуун хорин есөн мянга хоёр зуун тавин гурван төгрөг арван нэгэн мөнгө) төгрөгийн балансын үнэ бүхий, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, цаашид ашиглаж болох хөрөнгийн ашиглах хугацааг сунгаж, нийт үнийг 1,216,444,361.98 (нэг тэрбум хоёр зуун арван зургаан сая дөрвөн зуун дөчин дөрвөн мянга гурван зуун жаран нэгэн төгрөг ерэн найман мөнгө) төгрөгөөр хавсралтад заасны дагуу шинэчлэн тогтоохыг зөвшөөрсүгэй.

2. Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Тавинбэх, "Диспетчерийн үндэсний төв" төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн гүйцэтгэх захирал Г.Балжинням нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хөрөнгийн ашиглалтын хугацаа, үнийг шинэчлэн тогтоох ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусгах;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2024 оны 4 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА


ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

Д.НАРАНГЭРЭЛ

132002002
20-r huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2024 оны 09 дүгээр сарын-н өдрийн
..... дугаар тогтоолын хавсралт



"ДИСПЕТЧЕРИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ" ТӨРИЙН ӨМЧИТ ХЯЗГААРЛАГДМАЛ
ХАРИУЦЛАГАТАЙ КОМПАНИЙН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ, ҮЛДЭХ ӨРТӨГГҮЙ,
АШИГЛАЛТЫН ХУГАЦААГ СУНГАЖ, ҮНИЙГ ШИНЭЧЛЭН ТОГТООХ ХӨРӨНГИЙН
ТОВЧОО

Д/д	Хөрөнгийн ангилал	Тоо хэмжээ	Балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Шинэчлэн тогтоосон нийт үнэ (төгрөг)
1	Тоног төхөөрөмж	2246	3,285,572,227.61	620,735,823.51
2	Тавилга, эд хогшил	282	143,933,147.36	19,435,591.17
3	Компьютер, дагалдах хэрэгсэл	207	694,990,256.28	122,380,718.15
4	Бусад үндсэн хөрөнгө	2	1,600,000.00	323,373.17
5	Програм хангамж	51	5,799,233,621.86	453,568,855.97
		2788	9,925,329,253.11	1,216,444,361.98
	Нийт дүн		(есөн тэрбум есөн зуун хорин таван сая гурван зуун хорин есөн мянга хоёр зуун тавин гурван төгрөг арван нэгэн мөнгө)	(нэг тэрбум хоёр зуун арван зургаан сая дөрвөн зуун дөчин дөрвөн мянга гурван зуун жаран нэгэн төгрөг ерэн найман мөнгө)